



IV-VI/2023

Тархаасан: 2023 оны 9 дүгээр сарын 13



2023 оны 2 дугаар улирлын байдлаар ААНБ-ын ажиллагчдын сарын медиан цалин 1435.2 мянган төгрөг байна

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2023 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 50.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын 757.2 мянган ажиллагч хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) төлж буй ААНБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 1.7 (3.6%) мянгаар өмнөх улирлаас 730 (1.5%)-аар, харин ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 14.7 (2.0%) мянгаар өмнөх улирлаас 20.3 (2.8%) мянгаар тус тус өсжээ.

ХҮСНЭГТ 1. НДШ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАНД ХАМРАГДСАН ДААТГУУЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, жил бүрийн 2 улирлын байдлаар


Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2021 IV-VI	2022 IV-VI	2023 IV-VI
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	18 110	18 988	18 789
Уул уурхай, олборлолт	40 057	42 406	45 159
Боловсруулах үйлдвэрлэл	74 404	75 288	77 886
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	13 368	13 626	13 119
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	8 780	8 746	8 271
Барилга	46 597	50 869	52 066
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	89 544	104 249	109 959
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	43 611	44 301	50 375
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	13 574	16 604	16 589
Мэдээлэл, холбоо	15 768	18 141	17 778
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	27 726	29 583	29 277
Үл хөдлөх үйл ажиллагаа	2 961	3 479	3 749
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	22 143	23 813	23 800
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	24 789	26 398	27 200
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	78 664	79 577	76 821
Боловсрол	104 694	108 645	109 348
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	44 755	47 377	46 771
Урлаг, үзвэр, тоглоом наадам	7 773	8 485	8 427
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	17 311	18 614	18 386
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	499	760	778
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2 145	1 715	1 858
БҮГД	698 238	742 507	757 162

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан нийт даатгуулагчийн 109.3 (14.4%) мянга нь боловсролын салбарын, 110.0 (14.5%) мянга нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарын, 76.8 (10.1%) мянга нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарын, 77.9 (10.3%) мянга нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын, 46.8 (6.2%) мянга нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын, 52.0 (6.9%) мянга нь барилгын салбарын, 50.4 (6.7%) мянга нь тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын, 45.1 (6.0%) мянга нь уул, уурхай олборлолтын салбарын, 29.3 (3.9%) мянга нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын, 158.7 (21.0%) мянга нь бусад салбарын ажиллагчид байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2023 оны 2 дугаар улирлын тайланд хамрагдсан 757.2 мянган ажиллагчдын сарын медиан цалин 1435.2 мянган төгрөг байна. Медиан цалин өмнөх улирлаас 82.3 (6.1%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

Нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 1.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 345.6 (22.4%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 59.2 (3.2%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

ЗУРАГ 1. ААНБ-ЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН БОЛОН МЕДИАН ЦАЛИН, УЛИРЛААР, МЯНГАН ТӨГРӨГӨӨР




Дундаж цалинг хүйсээр авч үзвэл, 2023 оны 2 дугаар улирлын байдлаар эрэгтэйчүүдийнх 2.1 сая, эмэгтэйчүүдийнх 1.7 сая төгрөг байна.

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын цалин хамгийн их буюу 5.5 сая төгрөг, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт ажиллагчдын цалин хамгийн бага буюу 1.2 сая төгрөг байна.

ААНБ-д ажиллагчдын сарын дундаж нэрлэсэн цалин 2023 оны 2 дугаар улиралд 2015 оноос 2.3 дахин нэмэгдсэн хэдий ч худалдан авах чадварыг илэрхийлэх бодит цалин 36.2 хувиар нэмэгджээ.

ЗУРАГ 2. БОДИТ ЦАЛИНГИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар, хувиар




ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАГЧИД, цалин хөлсний бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2023 оны 2 дугаар улирлын байдлаар

Цалин хөлсний бүлэг, төгрөг	2023 I-III		2023 IV-VI	
	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь
550 000 хүртэл	88 068	12.0	88 474	11.7
550 001 - 700 000	50 558	6.9	47 624	6.3
700 001 - 900 000	70 729	9.6	66 841	8.8
900 001 - 1 100 000	75 753	10.3	71 962	9.5
1 100 001 - 1 300 000	66 439	9.0	62 418	8.2
1 300 001 - 1 500 000	69 582	9.4	67 763	9.0
1 500 001 - 2 000 000	122 475	16.6	131 674	17.4
2 000 001 - 2 500 000	65 203	8.9	78 060	10.3
2 500 001 - 3 000 000	38 776	5.3	45 727	6.0
3 000 001 - 3 500 000	25 395	3.5	28 010	3.7
3 500 001- дээш	63 853	8.7	68 609	9.1


Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан нийт даатгуулагчийн дотор 1.5 саяас 2.0 сая төгрөгийн цалинтай даатгуулагчийн эзлэх хувь хамгийн их буюу 17.4 хувь, харин 3.0 саяас 3.5 сая төгрөгийн цалинтай даатгуулагчийн эзлэх хувь хамгийн бага буюу 3.7 хувь байна.

ЗУРАГ 3. АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ажиллагчдын тооны бүлгээр, мянган төгрөгөөр




ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин тухайн байгууллагын ажиллагчдын тооноос шууд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, ажиллагчдын тооны бүлэг ахих тутам сарын дундаж цалин нэмэгдэж байгааг дээрх зургаас харж болно.

ЗУРАГ 4. АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, бүсээр, мянган төгрөгөөр



2023 оны 2 дугаар улирлын байдлаар ажиллагчдын сарын дундаж цалинг бүсээр авч үзэхэд Улаанбаатар хотод 2.0 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 135.3 (7.2%) мянган төгрөгөөр их байхад бусад бүсэд улсын дунджаас 121.2-632.0 (6.4%-33.4%) мянган төгрөгөөр доогуур байна.

ЗУРАГ 5. АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН БОЛОН АЖИЛЛАГЧДЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, байгууллагын хариуцлагын хэлбэрээр, 2023 оны 2 дугаар улирлын байдлаар, мянган төгрөгөөр



Байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд хязгаарлагдмал хариуцлагатай компанид ажиллагчдын сарын дундаж цалин 2.0 сая төгрөг, хувьцаат компанид ажиллагчдын сарын дундаж цалин 2.2 сая төгрөг, төрийн өмчит үйлдвэрийн газарт ажиллагчдын сарын дундаж цалин 2.3 сая төгрөг, байгаа нь улсын дунджаас 123.7-380.4 (6.5%-20.1%) мянган төгрөгөөр их байна.

Харин бусад аж ахуйн нэгжид ажиллагчдын сарын дундаж цалин байгууллагын хариуцлагын хэлбэрээс хамааран улсын дунджаас 94.3-468.6 (5.0%-24.8%) мянган төгрөгөөр бага байна.

Төсөвт байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин өмнөх оны мөн үеэс 237.6 (18.3%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Ажиллагчдын сарын дундаж цалинг ажил, мэргэжлийн ангиллаар авч үзэхэд 2023 оны 2 дугаар улирлын байдлаар суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагчийн сарын дундаж цалин хамгийн их буюу 2.4 сая төгрөг, харин хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтных 1.0 сая төгрөг буюу хамгийн бага байна.

Ойлголт, тодорхойлолт:

Цалин хөлс нь: Үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, ажиллаагүй цагийн олговор болон бусад олговроос бүрдэх бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар суутгахаас өмнөх буюу нэрлэсэн цалин хөлс юм.

Жишээ нь: Иргэн Э-гийн бодогдсон цалин 1 750 232 төгрөг гэж үзээд, гарт олгох цалинг тооцоход 1 410 060 төгрөг болж байгааг доорх зурагт харууллаа.



Дундаж цалин хөлс нь тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

$$\bar{x} = \frac{\sum_{i=1}^n (w_i * x_i)}{\sum_{i=1}^n w_i}$$

\bar{x} – Дундаж цалин хөлс

x_i – Ажиллагчдын нийт цалин хөлс

w_i – Ажиллагчдын тоо

Нэрлэсэн цалин нь хэрэглээний үнийн индексээр засварлагдаагүй, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлдэггүй бөгөөд татвар суутгал хасагдаагүй цалин, хөлс юм.


Нэрлэсэн цалингийн индекс нь тайлант болон суурь хугацаа (жил, улирал)-ны нэрлэсэн дундаж цалин хөлсний хувиар илэрхийлсэн харьцаа байна.

Бодит цалин нь нэрлэсэн цалингийн хэрэглээний үнийн индексээр засварлагдсан, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлт юм.

Бодит цалингийн индексийг тооцохдоо нэрлэсэн цалингийн индексийг, тайлант хугацааны хэрэглээний үнийн индексэд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

Медиан цалин нь ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм.

Медиан цалин 1 285 323 ₮



Ажиллагчдын тоо тэгш тоо байвал: $M_e = \frac{n}{2} + 1$

Хэрэв ажиллагчдын тоо сондгой тоо байвал: $M_e = \frac{n+1}{2}$

M_e – Цувааны төвд орших ажилтны цалин
 n – Нийт ажиллагчдын тоо



Эх үүсвэр:

Нийгмийн даатгалын ерөнхий газар

Мэдээлэл авах линк:

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2023 оны 12 дугаар сарын 15

Нийгмийн статистикийн газрын дарга
Э.Эрдэнэсан
Утас: (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын статистикч
Л.Буянжаргал
Утас: (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212